



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/463

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулж, тов тогтоох,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Намрын ногоон өдөр 2023”, үзэсгэлэн худалдааг 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдрөөс 09 дүгээр сарын 12-ны өдөр Чингүнжавын талбайд зохион байгуулсугай.

2. Дээрх арга хэмжээг зохион байгуулах, шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, арга хэмжээтэй холбогдон гарах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Арга хэмжээний зардлын 8,500,000 (Найман сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын бараа үйлчилгээний бусад зардлаас гарган зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т зөвшөөрсүгэй.

4. Иргэд, олон нийтэд сурталчлах, төсөлд оролцогч талуудын уялдаа холбоог сайжруулж, төслийн үр дүнг дээшлүүлэх, удирдамжийн дагуу зохион байгуулж, ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

5. Үзэсгэлэн худалдаанд орон нутгийн бизнес эрхлэгч, жижиг, дунд үйлдвэр эрхлэгч нарыг дэмжин, бэлтгэл зохион байгуулалтыг ханган оролцуулахыг сумдын Засаг дарга, холбогдох агентлаг, байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

6712010961

Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар
сарын 29-ний өдрийн 4/45 дүгээр
захирамжийн 1 дүгээр хавсралт

**“НАМРЫН НОГООН ӨДӨР 2023” ҮЗЭСГЭЛЭН
ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛАХ, ШАЛГАРУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Оюунтуяа

(Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

М.Даваадулам

(Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Д.Батцоож

(Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга)

Н.Үүрийнцолмон

(Эрүүл мэндийн газар хяналтын хэлтсийн дарга, эрүүл ахуй, халдвар
хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч)

Б.Цолмонбаяр

(Хүнс, хөдөө аж ахуйн газрын Газар тариалан үйлдвэрлэл, техник
технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Ч.Ганчимэг

(Мөрөн сумын Хүнс, худалдаа үйлдвэрлэл үйлчилгээ, хоршооны
асуудал хариуцсан мэргэжилтэн)

Д.Гэрэлтуяа

(Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга)

Б.Цэцгээ

(Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг)

Нарийн бичгийн дарга:

Б.Буянтогтох

(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн
мэргэжилтэн)

оОо

Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар
сарын 29-ний өдрийн А/453 дүгээр
захирамжийн 2 дугаар хавсралт

“НАМРЫН НОГООН ӨДӨР 2023” ҮЗЭСГЭЛЭН
ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Шагналын төрөл	Тоо хэмжээ	Шагнал	Тус брийн мөнгөн дүн	Нийт мөнгөн дүн
1	Аймгийн шилдэг бүтээгдэхүүн	1	Батламж цом	600,000	600,000
2	Орон нутгийн онцолгийг харуулсан шилдэг бүтээгдэхүүн	3	Өргөмжлөл	300,000	900,000
3	Шилдэг технологитой бүтээгдэхүүн	1	Өргөмжлөл	300,000	300,000
4	Импортыг орлох бүтээгдэхүүн	1	Өргөмжлөл	300,000	300,000
5	Шилдэг гар урлал болон оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэгч	3	Өргөмжлөл	300,000	900,000
6	Шилдэг үйлдвэрлэгч сум	1	Өргөмжлөл	600,000	600,000
7	Шилдэг зохион байгуулалттай сум	1	Өргөмжлөл	600,000	600,000
8	Шилдэг хоршоо, бүлэг	2	Өргөмжлөл	200,000	400,000
9	Баялаг бүтээгч өрх	5	Өргөмжлөл	150,000	750,000
10	Шилдэг газар тариалан эрхлэгч	3	Өргөмжлөл	300,000	900,000
11	Тайз чимэглэх зардал				625,000
12	Өргөмжлөл, батламж	21		55,000	1,155,000
13	Цом	1		70,000	70,000
13	Үйл ажиллагааны бусад зардал				400,000
Нийт					8,500,000

оОо